



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/625

Булган сум

Эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.9 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн “Булган аймгийн 2025 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Х/74 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ургац тээврийн авто зам засварын ажилд зориулан Сэлэнгэ сумын Засаг дарга (А.Ганбагана)-д 15,000,000 (арван таван сая) төгрөг, Тэшиг сумын Засаг дарга (Б.Гансүх)-д 20,000,000 (хорин сая) төгрөг, Хангал сумын Засаг дарга (С.Ичинхорлоо)-д 20,000,000 (хорин сая) төгрөг, Хутаг-Өндөр сумын Засаг дарга (Ж.Ууганбаяр)-д 15,000,000 (арван таван сая) тус тус захиран зарцуулах эрхийг олгосугай.

2. Ургац тээврийн авто зам засварын ажилд зарцуулах эрх олгогдсон хөрөнгийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулж, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, тайлагнахыг Сэлэнгэ, Тэшиг, Хангал, Хутаг-Өндөр сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Дээрх ажлыг гүйцэтгэхэд шаардагдах хөрөнгийг аймгийн авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд батлагдсан “Ургац тээврийн авто замын засвар” зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (О.Сайнзаяа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР



6325010866